



## “БАГАНУУР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

### Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.3, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 11:00 цагт Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13 дугаар хороолол, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж 23-01 тоотод байрлах “Багануур-Илч” ХХК-ийн байрны 2 дугаар давхрын хурлын танхимд хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:

- 2.1 “Багануур” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах. /Гүйцэтгэх захирал Э.Номинчулуун/
- 2.2 Компанийн 2021 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах. /Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал Д.Ганзориг/
- 2.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай. /Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ц.Батсайхан/
- 2.4 Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай.

3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг нэгдүгээр хавсралтаар баталж 2022 оны 3 дугаар сарын 21-ний өдөрт багтаан “Санхүүгийн зохицуулах хороо”, “Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгүүлэх, Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг хоёрдугаар хавсралтаар баталж 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хувьцаа эзэмшигчдэд олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хүргэх, зарыг 2022 оны 4 дүгээр сарын 7-ны өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин сурталчлахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг гуравдугаар хавсралтаар, хэлэлцэх асуудалтай холбогдох танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар, хэлэлцэх асуудлаар санал авах хуудсыг тавдугаар хавсралтаар, хувьцаа эзэмшигчдийн хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох санал авах хуудасны загварыг зургаадугаар хавсралтаар, хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийн хяналтын хуудсыг долоодугаар хавсралтаар тус тус баталсугай.

5. Хуралд бэлтгэх, зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

**а.Хурал даргалагч:**

О.Хулан /"Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч/

**б Хурал зохион байгуулах комиссын дарга**

Г.Ганзориг /Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга/

**в. Хурал зохион байгуулах гишүүд**

С.Сэргэлэн / Багануур ХК-ийн хуулийн зөвлөх/

Г.Төмөрбаатар /Багануур-Илч ХХК-ийн гүйцэтгэх захирал/

У.Батсуурь /Багануур ХК-ийн төлөөлөгчийн газрын менежер/

С.Одончимэг /Хэвлэл мэдээллийн ажилтан/

Б.Долгион /Гүйцэтгэх захирлын туслах/

А.Ганболор /Багануур ХК-ийн ажилтан/

**г. Хурал зохион байгуулах тооллогын комиссын дарга**

Б.Наранчимэг/ Дотоод хяналт шалгалтын албаны дарга

**д. Тооллогын комиссын гишүүд**

Д.Даваадаш / Санхүү бодлогын хэлтсийн мэргэжилтэн

Б.Наранцэцэг / дотоод хяналт шалгалтын албаны мэргэжилтэн/

6. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийг жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 4 дүгээр сарын 8-ны өдрөөр тогтоосугай.

7. Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл түүнтэй холбогдох баримт бичгийг 2022 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор хүргүүлнэ.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудсыг брокер, дилерийн компаниудаар дамжуулан хүлээн авах эцсийн хугацааг 2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 17:00 цагаар тасалбар болгосугай.

9. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг гүйцэтгэх захирал /Э.Номинчулуун/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.БАТСАЙХАН





Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2022 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн  
01 дугаар тогтоолын 1. дүгээр хавсралт

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

2022.03.18

Улаанбаатар хот

Компанийн нэр :	Багануур ХК
Хаяг, утас:	Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 3-р хороо, Үйлдвэр хэсэг
Хурал хуралдах өдөр цаг:	2022 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 11:00 цаг
Хурал хуралдах газар /хаяг, байршил/	Улаанбаатар хот, БЗД, 13-р хороолол, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж, 23-01 тоотод байрлах “Багануур-Илч” ХХК-ийн 2 давхарт хурлын танхим
Хурлын төрөл	Ээлжит хурал
Хурал зарлагч	Багануур ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо	2022 оны 3-р сарын 18-ны өдөр
Олон нийтэд зарлах огноо:	2022 оны 3-р сарын 23-ны өдөр
Бүртгэлийн өдөр	2022 оны 4-р сарын 8-ны өдөр
Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер,дилерийн компанид хүргүүлэх огноо	2022 оны 4-р сарын 1-ний өдөр
Хурлын даргын нэр:	О.Хулан “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр	Б.Наранчимэг, Б.Наранцэцэг, Д.Даваадаш
Баримт, бичгийн жагсаалт /хавсралтаар/	
Баримт, бичгийн хуудасны тоо	.....ширхэг .....хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

.....

/...../



Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2022 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн  
3 дугаар тогтоолына дүгээр хавсралт

## “БАГАНУУР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

2022 оны 3 дугаар сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

“Багануур” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 11:00 цагт “Багануур ХК-ийн Улаанбаатар хот дахь Төлөөлөгчийн газрын хурлын танхимд хуралдаж дараах асуудлуудыг хэлэлцэнэ.

1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай.
2. Компанийн 2021 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 4 дүгээр сарын 8-ны өдрөөр, хувьцаа эзэмшигчийн саналын хуудсыг хүлээн авах эцсийн өдрийг 2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 17:00 цагаар тасалбар болгоно.

Хувьцаа эзэмшигч та бүхэн хурлын холбогдох материалтай 2022 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн “Багануур-Илч” ХХК, харьяа брокер, дилерийн компанид ирж танилцан хуралд идэвхтэй оролцоно уу.

### Хурал хуралдуулах газрын хаяг:

“Багануур ХК-ийн охин компани Багануур Илч ХХК-ийн 2 давхарт 103 тоот хурлын танхимд /Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13-р хороолол, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж 23-1 тоот/

### Лавлах утас:

“Багануур-Илч” ХХК, утас 70157719

Хурал зохион байгуулах комисс: 99168048



Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2022 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн  
дугаар тогтоолын 5 дүгээр хавсралт

### “БАГАНУУР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

№	Хурлын дэг	Хугацаа
1	Хурлын ирц бүртгэх	10.00-11.00
2	Хурлын ирц мэдээлэх /Зохион байгуулах комисс/	5 минут
3	Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргыг танилцуулах	5 минут
4	Хурлын дарга хурлын үйл ажиллагааг нээж хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулах	10 минут
5	Хэлэлцэх асуудлыг дарааллын дагуу танилцуулах	Асуудал тус бүрээр 30 хүртэл минут
6	Хуралд оролцогсдын асуулт, хариулт	Хүн бүр 3 минут
7	Хуралд оролцогсдын санал	Хүн бүр 3 минут
8	Завсарлага	20 минут
9	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	5 минут
10	Хурлаас гарах шийдвэрийн төслийг танилцуулж, батлуулах	Асуудал тус бүрээр 15 минут
11	Хурлын ажиллагааг хаах	5 минут

**Хурал зохион байгуулах комисс**



Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2022 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн  
01 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**“БАГАНУУР” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР  
ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБОГДОХ ТАНИЛЦАЖ БОЛОХ  
БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

1. “Багануур” ХК-ийн 2021 оны үйл ажиллагааны тайлан
2. “Багануур” ХК-ийн 2021 оны аудитлагдсан санхүүгийн тайлан
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төслүүд

**Хурал зохион байгуулах комисс**





Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2022 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн  
27 дугаар тогтоолын 5 дүгээр хавсралт

## БАГАНУУР ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛААР САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог ..... нэр.....

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар.....

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар.....

Санал өгөх хувьцааны тоо.....

Бүртгэсэн /брокер, дилерийн компани/

Брокерийн овог..... нэр.....

Багануур ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2022 оны 4-р сарын 28-ны өдрийн 11:00 цагт “Багануур” ХК-ийн охин компани болох “Багануур Илч” ХХК-ийн 2 давхарт 103 тоот хурлын танхимд болно.

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түтгэлзсэн
1	Компанийн 2021 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай.			
2	Компанийн 2021 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай.			
3	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох тухай.			

Брокерийн...../...../

Хувьцаа эзэмшигчийн...../...../







Төлөөдөн удирдах зөвлөлийн  
2022 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн  
дугаартай тогтоолын 7 дугаар хавсралт

### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЛИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС

№	Зүйл	Тайлбар
1	Компанийн нэр:	
2	Хаяг, байршил:	
3	ТУЗ-ийн хурал хийсэн огноо:	
4	Хурал зарлагчийн мэдээлэл:	
5	Хороонд ирүүлсэн огноо /хурал хуралдуулах шийдвэр гарсанаас хойш 3 хоногийн дотор/:	
6	Олон нийтэд зарлах огноо /хурал хуралдуулах шийдвэр	
7	Эхний зарласнаас хойш 15 хоногт дахин зарласан эсэ	
8	Бүртгэлийн өдөр /нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 15-20 дахь өдөр	
9	Хэлэлцэх асуудал /Компанийн тухай хуулийн 60.2 дахь заалттай нийцэж буй эсэх/	
10	Саналын хуудасны загвар:	
11	Саналын хуудас хүлээн авах өдөр	
12	Хурлын комиссын гишүүдийн нэрс	
13	Хурал хуралдуулах огноо /шийдвэр гарснаас хойш 40-өөс доошгүй хоногийн өмнө/	
14	Хурал хуралдуулах газар, байршил, хаяг:	
	Хурал хуралдуулах огноо, цаг	
15	Хурлын мэдэгдэл хянасан хянан шалгагчийн нэр:	
	Хурлын мэдэгдэл хянасан хянан шалгагчийн гарын үс	
	Хурлын мэдэгдэл хянасан огноо	